ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Баянтүмэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны хураангуй санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: ДОА-2024/09/НА-СТА-ТТЗ**

Цахим хуудас: www.audit.mn
Чойбалсан хот
2024 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Б.Болортуул
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер: И.Сэмжидмаа
Утас: 7058-4204, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Нармандах
Утас: 7058-4207, Цахим хаяг:narmandakhd@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Аудитын илрүүлэлт
4. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| ЗДТГ | Засаг даргын Тамгын газар |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ТТЗ | Төсвийн төвлөрүүлэн захирагч |
| ХХС | Хоршоо хөгжүүлэх сан |

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
[illegible]

№ 312

танай ______ -ны № ______ -т

БАЯНТҮМЭН СУМЫН ЗАСАГ ДАРГА
Э.НАРАНГАРАВ ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Баянтүмэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянтүмэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

### Аудитын гол асуудал

Тус сум нь 2023 оныг "Өрхийн орлогыг нэмэгдүүлэх" жил болгон хөгжлийн жилийн төлөвлөгөөний хүрээнд 2 зорилтын хүрээнд 99 арга хэмжээ хэрэгжүүлэхээр баталсан байна. Сумын ИТХ-ын 2023 оны 16/10 дугаар тогтоолоор хэрэгжилтийг 95 хувиар хангалтай гэж дүгнэсэн байна.

### Бусад асуудлын хэсэг

Тайлант оны 777.5 сая төгрөгийн худалдан авах ажиллагааны жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг хүргүүлэн ажиллаагүй байна.

Оны эцэст нэмэгдүүлэн баталсан хөрөнгө оруулалтын 377.0 сая төгрөгийн 9 арга хэмжээг худалдан авах төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт хийн батлаагүй.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/ мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2022оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **664,335.30** | **934,545.80** |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 250,657.90 | 604,994.20 |
| 33 | АВЛАГА | 210,657.70 | 176,912.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 185,482.30 | 152,639.60 |
| 36 | НӨӨЦИЙН БАРАА | 17,537.40 | 0 |
| 2 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,473,179.10** | **2,786,348.30** |
| 39 | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 2,473,179.10 | 2,786,348.30 |
| 39200 | **Биет хөрөнгө** | 2,286,909.40 | 2,546,865.10 |
| 39300 | **Биет бус хөрөнгө** | 186,269.70 | 239,483.20 |
| 3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **3,137,514.40** | **3,720,894.10** |
| 4 | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **3,182.50** | **97,817.50** |
| 41 | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 3,182.50 | 97,817.50 |
| 41300 | Өглөг | 3,182.50 | 97,817.50 |
| 5 | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **3,134,331.90** | **3,623,076.60** |
| 51 | **Засгийн газрын хувь оролцоо** | **3,134,331.90** | **3,623,076.60** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 642,586.80 | 642,586.80 |
| 51200 | **Хуримтлагдсан үр дүн** | 2,258,158.30 | 2,746,903.00 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 233,586.80 | 233,586.80 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **3,137,514.40** | **3,720,894.10** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/ мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2022 оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 3,194,848.50 | 4,116,966.50 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 383,846.50 | 1,635,561.30 |
| 110 | Орлогын албан татвар | 169,260.70 | 965,596.10 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 179,226.10 | 975,579.00 |
| 1101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | -9,965.40 | -9,982.90 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 101,691.80 | 222,615.30 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 112,894.00 | 447,349.90 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1,116,342.50 | 786,745.70 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 909,742.50 | 756,395.70 |
| 122 | Тусламжийн орлого | 206,600.00 | 30,350.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,694,659.50 | 1,694,659.50 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 1,889,615.30 | 1,607,125.20 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,889,615.30 | 1,607,125.20 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,064,254.20 | 1,415,300.40 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 371,031.80 | 533,697.70 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 46,150.10 | 63,808.20 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 76,957.40 | 5,786.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 41,785.70 | 100,779.00 |
| 2105 | Нормативт зардал | 22,214.80 | 2,325.80 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 21,702.70 | 3,610.30 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 61,580.90 | 11,267.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 7,238.80 | 95,836.70 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 415,592.00 | 598,189.70 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 825,361.00 | 191,824.70 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 1,305,233.20 | 1,372,737.90 |
| V | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 2,282,764.50 | 883,993.10 |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | -977,531.20 | 488,744.70 |

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Цөөнхийн хувь оролцоо | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|---|---|---|---|---|
| 1 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 4,168,532.90 | 0 | 4,168,532.90 |
| 10 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 3,134,331.90 | 0 | 3,134,331.90 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 4,111,863.20 | 0 | 4,111,863.20 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | -56,669.70 | 0 | -56,669.70 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | -977,531.20 | 0 | -977,531.20 |
| 11 | 2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 3,134,331.90 | 0 | 3,134,331.90 |
| 20 | 2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 3,623,076.60 | 0 | 3,623,076.60 |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 3,134,331.90 | 0 | 3,134,331.90 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 488,744.70 | 0 | 488,744.70 |

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2022оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 2,471,372.40 | 2,384,844.80 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 383,846.50 | 1,635,561.30 |
| 110 | Орлогын албан татвар | 169,260.70 | 965,596.10 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 179,226.10 | 975,579.00 |
| 1101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | -9,965.40 | -9,982.90 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 101,691.80 | 222,615.30 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 112,894.00 | 447,349.90 |
| 1180 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | 3,931.80 | 40,616.90 |
| 1181 | Газрын төлбөр | 108,962.20 | 406,733.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 516,866.40 | 190,501.70 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 310,266.40 | 160,151.70 |
| 122 | Тусламжийн орлого | 206,600.00 | 30,350.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,570,659.50 | 558,781.90 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,665,619.50 | 1,204,034.20 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,665,619.50 | 1,204,034.20 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 840,258.60 | 1,012,209.50 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 371,031.80 | 534,032.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 46,150.10 | 63,808.20 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 76,957.40 | 5,786.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 40,196.30 | 41,845.80 |
| 2105 | Нормативт зардал | 22,210.80 | 1,356.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 22,022.20 | 16,559.50 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 61,580.90 | 11,167.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 7,458.80 | 95,836.70 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 192,650.10 | 241,818.10 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 825,361.00 | 191,824.70 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 805,752.90 | 1,180,810.60 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 816,432.70 | 789,574.30 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 816,432.70 | 789,574.30 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 816,432.70 | 789,574.30 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | -816,432.70 | -789,574.30 |
| VII | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН | -105,550.00 | -36,900.00 |
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 105,550.00 | 36,900.00 |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | -116,229.80 | 354,336.30 |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 366,887.70 | 250,657.90 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 250,657.90 | 604,994.20 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| II | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2,382,265.50** | **1,837,043.90** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **924,824.50** | **1,010,569.60** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **874,091.20** | **818,744.90** |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **543,355.00** | **533,582.10** |
| 210101 | Үндсэн цалин | 311,329.90 | 318,017.20 |
| 210102 | Нэмэгдэл | 183,053.90 | 156,477.70 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 21,912.00 | 18,581.90 |
| 210104 | Урамшуулал | 27,059.20 | 35,457.20 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 0 | 5,048.10 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **69,301.50** | **63,808.30** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 47,168.10 | 43,287.30 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,544.10 | 5,131.10 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,435.30 | 4,199.20 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,108.80 | 1,008.30 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 11,045.20 | 10,182.40 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **90,598.00** | **76,863.10** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 50,092.40 | 38,003.90 |
| 210302 | Түлш, халаалт | 36,060.00 | 37,135.20 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,445.60 | 1,724.00 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | **45,605.20** | **41,572.20** |
| 210401 | Бичиг хэрэг | 4,663.50 | 4,758.40 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 36,657.10 | 32,630.50 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,138.00 | 2,037.70 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 71.00 | 70.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,075.60 | 2,075.60 |
| 2105 | **Норматив зардал** | **1,356.50** | **1,356.00** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,356.50 | 1,356.00 |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **20,429.60** | **20,409.70** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 12,500.00 | 12,494.70 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 78.60 | 64.80 |
| 210604 | Урсгал засвар | 7,851.00 | 7,850.20 |
| 2107 | **Томилолт, зочны зардал** | **9,621.00** | **9,139.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 9,621.00 | 9,139.00 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **3,750.50** | **2,480.30** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр | 1,356.20 | 1,115.50 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 215.50 | 107.60 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 81.80 | 48.70 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 77.00 | 66.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,488.00 | 755.50 |
| 210807 | Газрын төлбөр | 400.00 | 387.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 132.00 | 0 |
| 2109 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **90,073.90** | **69,534.20** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 89,842.80 | 69,303.10 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 231.10 | 231.10 |
| 213 | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **50,733.30** | **191,824.70** |
| 2131 | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | **0.00** | **161,575.50** |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 0 | 161,575.50 |
| 2132 | **Бусад урсгал шилжүүлэг** | **50,733.30** | **30,249.20** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 8,368.60 | 8,368.60 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 41,422.80 | 20,980.60 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 941.90 | 900.00 |
| 22 | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **1,368,480.00** | **789,574.30** |
| 223001 | Бусад хөрөнгө | 1,368,480.00 | 789,574.30 |
| 23 | **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | **88,961.00** | **36,900.00** |
| 230001 | Эргэж төлөгдөх зээл | 88,961.00 | 36,900.00 |
| III | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **2,382,265.90** | **2,337,849.30** |
| 32 | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,903,427.50** | **1,578,883.90** |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 1,446,713.90 | 1,145,919.40 |
| 320002 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 456,713.60 | 432,964.50 |
| 35 | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **282,188.40** | **728,615.40** |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 77,361.00 | 73,774.40 |
| 350002 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 600.00 | 550,000.00 |
| 350003 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 204,227.40 | 104,841.00 |
| 36 | **ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ** | **196,650.00** | **30,350.00** |
| 360001 | Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих | 196,650.00 | 30,350.00 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0 | 141,959.20 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0 | 93,314.70 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Код | Үзүүлэлт | 2022оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| II | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **111,576.70** | **125,817.40** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **111,576.70** | **125,817.40** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **109,192.50** | **113,660.10** |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,979.00** | **450.00** |
| 210104 | Урамшуулал | 1979.0 | 450.00 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | **22,158.00** | **18,702.80** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,593.70 | 0.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 20564.3 | 18,702.80 |
| 2105 | **Норматив зардал** | **22,210.80** | **0.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 974.00 | 0.00 |
| 210502 | Хоол, хүнс | 21,236.80 | 0.00 |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **2,305.00** | **0.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,500.00 | 0.00 |
| 210604 | Урсгал засвар | 805.00 | 0.00 |
| 2107 | **Томилолт, зочны зардал** | **57552.0** | **2,028.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 57552.0 | 2,028.00 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **2,572.60** | **0.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,572.60 | |
| 2109 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **415.10** | **92,479.30** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 415.1 | 92,479.30 |
| 213 | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **2,384.20** | **12,157.30** |
| 2133 | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **2,384.20** | **12,157.30** |
| 213405 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 2384.2 | 12,157.30 |
| I | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **111,457.10** | **125,817.40** |
| 1311 | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **111,457.10** | **125,817.40** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0.0 | 7,752.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 102273.2 | 57,794.80 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 9183.9 | 60,270.60 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 119.60 | 0 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,315.7 сая төгрөгийн зөрчил[1] илэрсэнд 3 албан шаардлага, 377.0 сая төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

### 3.1 Албан шаардлага

1. Сумын ТТЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр төсөл, арга хэмжээний нийт хэрэгжилт 97.5 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнд: ОНХС-гийн санхүүжилтээр хийгдэх 80.0 сая төгрөгийн /нэгдсэн халаалтын зураг төсвийн-60.0 сая, гүн өрмийн худгийн цооног гаргах-20.0 сая/ 2 арга хэмжээ огт хэрэгжээгүй байна. Энэ нь төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.7-д "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.
2. Сумын нийт орлого 1.652.6 сая төгрөг болж 44.3 сая төгрөг буюу 2.8 хувиар давж биелсэн байна. Гэвч шууд бус татварын орлого 33.8 хувь буюу 0.3 сая төгрөгөөр, бууны татвар 30.0 хувь буюу 0.5 сая төгрөгөөр, малын тоо толгойн албан татвар 17.1 хувь буюу 45.5 сая төгрөгөөр, газрын төлбөр 25.5 хувь буюу 114.9 сая төгрөгөөр тус тус тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

**Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

3. Тайлант оны 777.5 сая төгрөгийн худалдан авах ажиллагааны жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг хүргүүлэн ажиллаагүй байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

### 3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой.**

**1.** *Илрүүлэлт:* Тус газрын хөрөнгөд бүртгэлтэй 2 тээврийн хэрэгслийн улсын дугаарын дэвсгэр өнгийг тод хөх өнгө болгон өөрчлөөгүй байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн автотээврийн хэрэгсэлд бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ", MNS 4410-1:2002 стандартын 5.4.9-т "Төрийн болон орон нутгийн өмчит бүртгэлтэй автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын дэвсгэр нь хар хөх, тоо, үсэг ба хүрээ нь цагаан өнгөтэй байна" гэснийг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

*Өгсөн зөвлөмж*: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4, MNS 4410-1:2002 стандартын 5.4.9-т нийцүүлэн тээврийн хэрэгслийн улсын дугаарын дэвсгэр өнгийг тод хөх өнгө болгох.

**2.** *Илрүүлэлт:* Оны эцэст нэмэгдүүлэн баталсан 377.0 сая төгрөгийн 9 арга хэмжээг худалдан авах төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт хийн батлан ажиллаагүй байна.

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

*Өгсөн зөвлөмж*: Худалдан авах төлөвлөгөөг батлан ажиллах.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын байгууллагад 30 хоногийн дотор, харин зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Хүрэх үр дүнг хангаж ажиллаагүй | 1 | 0 | - | - | 1 | 0 | - | - |
| Орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр биелүүлэн ажиллаагүй | 1 | 161.1 | - | - | 1 | 161.1 | - | - |
| **Нийт дүн** | **2** | **161.1** | **-** | **-** | **2** | **161.1** | **-** | **-** |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/сая төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| - - | - | - | - | - | - | - | - | - |
| Дүн | - | - | - | - | - | - | - | - |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Худалдан авах ажиллагааны жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг хүргүүлэн ажиллаагүй | 1 | 777.5 | | | 1 | 777.5 | | |
| Худалдан авах төлөвлөгөө батлаагүй | 1 | 377.0 | - | - | - | - | 1 | 377.0 |
| Тээврийн хэрэгслийн улсын дугаарын дэвсгэр өнгийг тод хөх өнгө болгоогүй. | 1 | 0 | | | | | 1 | 0 |
| Дүн | 3 | 1,154.5 | - | - | 1 | 777.5 | - | - |
| **Нийт дүн** | **3** | **1,154.5** | **-** | **-** | **1** | **777.5** | **2** | **377.0** |

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 29 өдөр Дугаар 01/102 ДОА-2024/09/НА-ОА ТВЗ Чойбалсан хот

Д1160305

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянтүмэн сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр батлагдсан 80.0 сая төгрөгийн /нэгдсэн халаалтын зураг төсвийн-60.0 сая, гүн өрмийн худгийн цооног гаргах-20.0 сая/ 2 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т "Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ", 41.2.7-д "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 дэх "*хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал*" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүнг хангаж ажиллах, биелэлтийг 2024 оны 12 дугаар сарын 15-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянтүмэн сумын Засаг дарга Э.Нарангарав, санхүү албаны дарга Б.Эрдэнэцэцэг нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН МЕНЕЖЕР И.СЭМЖИДМАА

АХЛАХ АУДИТОР Д.НАРМАНДАХ

011041325

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 08 сарын 29 өдөр Дугаар 02/103 ДОА-2024/09/НА-СӨА-723 Чойбалсан хот
А1160305

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянтүмэн сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Малын тоо толгойн албан татварын орлого 17.1 хувь буюу 45.5 сая төгрөгөөр, газрын төлбөр 25.5 хувь буюу 114.9 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д *"Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй"*, 6.2.2-д *"жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх"; 41.2-д "Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ" 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх"* гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 дэх *"хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"* гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн орлогыг батлагдсан нэр төрлөөр биелүүлэн ажиллах, биелэлтийг 2024 оны 12 дугаар сарын 15-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянтүмэн сумын Засаг дарга Э.Нарангарав, санхүү албаны дарга Б.Эрдэнэцэцэг нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН МЕНЕЖЕР И.СЭМЖИДМАА

АХЛАХ АУДИТОР Д.НАРМАНДАХ

011041322

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 29 өдөр    Дугаар 03/104 ААА-2024/09/НА-СТА-ТТЗ А1160305    Чойбалсан хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянтүмэн сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны 777.5 сая төгрөгийн худалдан авах ажиллагааны жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг хүргүүлэн ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 дэх "*хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал*" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Цахим дэлгүүрт худалдан авах ажиллагааны жагсаалтыг байршуулах хүсэлтийг хүргүүлэх, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянтүмэн сумын Засаг дарга Э.Нарангарав, санхүү албаны дарга Б.Эрдэнэцэцэг нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН МЕНЕЖЕР И.СЭМЖИДМАА

АХЛАХ АУДИТОР Д.НАРМАНДАХ

011041319